

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/15.

Арвайхээр сум

Эрүүл мэндийн байгууллагын тусгай
зөвшөөрөл сунгах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2,19.3,19.14, 19.15, 19.18, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 14,15, 6.1 дүгээр зүйлийн 5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 03-ний өдрийн А/383 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын ажиллах журам”- ын 5.6. дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой ажлыг гүйцэтгэх ажлын албаны ирүүлсэн санал, салбарын хяналтын дүгнэлтийг үндэслэн аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгах нэр бүхий 1 байгууллагын нэрийг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга (Я. Жаргалд) -д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

622301040

Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 04 дугаар сарын 15-ны
өдрийн 14 дугаар тушаалын
хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ НЭР БҮХИЙ БАЙГУУЛЛАГА,
АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭР

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Сунгах хугацаа	Хүчинтэй байх хугацаа/огноо
1	"Чинмэнд" эмнэлэг	Дотор, хүүхэд, уламжлалт эмчилгээ, сувилал, дүрс оношилгоо, лабораторийн тусламж үйлчилгээ	Арвайхээр сум, 5-р баг	5 жилээр	2029 оны 04 дүгээр сарын 14 ны өдрийг хүртэл

---oOo---